



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 190

Улаанбаатар хот

“Улсын байцаагчийн урамшуулал олгох журам”-ыг
шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны “Улсын байцаагчийн урамшуулал олгох журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 222 дугаар тогтоолоор батлагдсан “Улсын байцаагчийн урамшуулал олгох журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Ц.Нацагдорж/-нд даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ,
ДЭД ДАРГА

Э.БАТБОЛД

